



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 4/196

Хархорин сум

Г

Т

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн нийтийн эзэмшлийн талбайн камерыг хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Лхагвабуд (Хотын захирагчийн албаны ерөнхий менежер)

Гишүүдэд: Н.Төгөлдөр (Байгаль хамгаалагч)

Д.Баярцэцэг (Байгаль хамгаалагч)

Н.Отгонбаяр (Засаг даргын Тамгын газрын нярав)

Нарийн бичгийн дарга: Э.Очир-Эрдэнэ (Архитектор)

2. Камерыг хүлээж авах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг (Г.Лхагвабуд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ОДГЭРЭЛ



401100391